

“ЭРДЭНЭТ БУЛГАНЫ ЦАХИЛГААН ТҮГЭЭХ
СҮЛЖЭЭ” ТӨХК-ИЙН ИРӨНХИЙ ИНЖЕНЕР
Б.ЭРДЭНЭЦОГТ



ХӨВСГӨЛ АЙМГИЙН ГАЛТ СУМЫН ЗҮРХ БАГИЙН НАРНЫ СТАНЦЫН ШИНЭЧЛЭЛИЙН ТЕХНИКИЙН ДААЛГАВАР

2024 оны ..10-р сарын ..08.-ны өдөр

Орхон аймаг

1. Ажлын даалгавар боловсруулах үндэслэл: Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль
Нарны цахилгаан станцын шинэчлэл /Хөвсгөл,
Галт сум, Зүрх баг/

2. Байршил: Хөвсгөл аймаг, Галт сум, Зүрх баг

3. Хийж гүйцэтгэх ажлын даалгавар:

3.1. 300 кВт*ц багтаамжтай лити /LFP эсвэл LiFePO4 / батарейг нийлүүлж, угсарч суурилуулна. Суурилуулах батарей нь дараах шаардлагуудыг хангасан байна. Үүнд:

3.1.1. LFP эсвэл LiFePO4 лити төрлийн батарей

3.1.2. Цэнэг алдалт /DOD/ 85 хувь байхад циклийн тоо 4000 доошгүй байх /+25°C температуртай үед/

3.1.3. Ажиллах температур -10°C - +45°C

3.1.4. Олон улсын IEC, CE, ISO стандарт шаардлагуудыг хангасан байна.

3.2. Нийт 60 кВт-аас багагүй хүчин чадалтай бие даасан /off grid эсвэл hybrid/ инвертерийг нийлүүлж, угсарч суурилуулна. Суурилуулах инвертер нь дараах шаардлагуудыг хангасан байна. Үүнд:

3.2.1. Бие даасан горимд ажиллах

3.2.2. Батарей цэнэглэх горимтой байх. Хэрэв байхгүй тохиолдолд цэнэг зохицуулагч суурилуулах

3.2.3. MPPT технологитой байх

3.2.4. Ажиллах температур -10°C - +55°C

3.2.5. Олон улсын IEC, CE, ISO стандарт шаардлагуудыг хангасан байна.

3.3. Нарны цахилгаан үүсгүүрийн систем нь бие даасан систем байх бөгөөд цаашид сүлжээтэй холбогдож ажиллах боломжтой байхаар тоноглолыг сонголтыг хийнэ.

3.4. Холболтын схемийг “ЭБЦТС” ТӨХК-ийн Архангай салбартай зөвшилцөн батлуулсан байх

3.5. Хуучин батарей болон инвертерийг буулгаж “ЭБЦТС” ТӨХК-ийн Архангай салбарт хүлээлгэн өгч баримтжуулсан байх

3.6. Ашиглалтад өгөхийн өмнө шаардлагатай туршилт хэмжилтүүдийг холбогдох стандартуудад нийцүүлэн хийх, акт протоколыг хүлээлгэж өгөх. /Батарей тус бүрийн хэмжилт, цэнэг алдалт хүчдэлийн бууралтын хэмжилт/

3.7. Уг системд нэмэлтээр хийгдэх цахилгаан станцын тоног төхөөрөмж угсралт суурилуулахтай холбоотой нийт ажлыг гүйцэтгэгч тал бүрэн хариуцах ба үүсэж болзошгүй нэмэлт зардлуудыг төлөвлөж “Түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр” тоног төхөөрөмжийн нийлүүлэлт, угсралт, суурилуулалтыг гүйцэтгэж хүлээлгэн өгнө.

3.8. Нарны цахилгаан станцын төхөөрөмжүүд нь /инвертер, цахилгаан самбарууд, бусад холбогдох төхөөрөмжүүд/ суурилуулах, тогтоох зориулалтын төмөр хийцүүдтэй байх бөгөөд салхи шуурга, байгалийн үзэгдлүүдэд тэсвэртэй байх.

3.9. Угсралт суурилуулалт хийх явцад нөхөн сэргээлтийн, цэвэрлэгээний ажлуудыг гүйцэтгэгч тал бүрэн хариуцаж хийнэ.

3.10. Одоо байгаа PV модулийн холболтыг шинээр суурилагдах инвертерд тохируулж угсралт, холболтыг өөрчилж болно.

3.11. Мэргэшсэн төсөвчнөөр төсөв хийлгүүлсэн байх /төсөвт: техникийн хяналт зардал болон холбогдох зардлыг тооцсон байна/

3.12. Тоноглолын ашиглалтын норм стандарт гарын авлага Монгол хэл дээр 3 хувь хэвлэж хүлээлгэн өгөх.

3.13. Тоноглолын ашиглалт, засвар үйлчилгээний чиглэлээр сургалтыг зохион байгуулах

3.14. Техникийн бичиг баримтын бүрдүүлэлтийг хийх, “ЭБЦТС” ТӨХК-д хүлээлгэж өгөх

3.15. Зуны улиралд баттарейн байгууламж дотор маш их халуун байдаг, мөн өвлийн улиралд баттарейн байгууламжийн өрөөний температурыг -10 хэмээс бууруулахгүй байхаар халаалт, хөргөлтийн систем хийх

Жич: Одоо ажиллаж байгаа нарны дэлгэц нь NT-RSE2E-175 Вт-ын 240 ширхэг, FS-M125-180 Вт-ын 120 ширхэг, TSM-165D 165 Вт-ын 120 ширхэг тус тус байгаа.

Горимын инженер



Ш.Мөнхтуул